

**ЭВ САНААНЫ НЭГДЛИЙН  
БАРИМТ БИЧИГ****Л. Жамсран**

МАХН байгуулагдсан цагаасаа эхлэн Хятадын ард түмэн, түүний хувьсгалчидтай ангийн эв санааны нэгдэлтэй байж, бие биеийн тэмцлийг харилцан дэмжиж туслахыг зорьж ирсэн билээ. МАХН тэр зорилтоо тус оронд ардын хувьсгал ялж хувьсгалт Монгол Улс үүсмэгц бодитой хэрэгжүүлж эхлэн, ялангуяа Хятадын 1924—1927 оны хувьсгалын үед ХКН, Гоминьдан намтай үе үе харилцаж уг хувьсгалыг дэмжиж байлаа. Гэтэл гоминьданы баруун жигүүр Хятадын хувьсгалаас урваж, улс орондоо зууч хөрөнгөтөн, газрын эздийн дарангуйлал тогтоож харгислахын сацуу олон улсын империалист харгис хүчинтэй хамсаж, тэдний тухиралтаар ууган социалист орон ЗХУ болон БНМАУ-ыг шууд заналхийлэн түрэмгийлэх явуулга хийх болсон юм.

Хэдүй тийм боловч, тэр хүнд жилүүдэд МАХН ХКН-ын хооронд ажил хэргийн хэлхээ холбоо тогтоох, Монгол, Хятадын үйлдвэрчний байгууллагуудын үйл ажиллагааг хөдөлмөрчин ангийн эв санааны нэгдлийн үндсэн дээр цаашид хөгжүүлэх бодит алхам хийж байлаа. Тухайлбал: 1929 оны 9-р сард ХКН-ын төлөөлөгч Улаанбаатар хотноо хүрэлцэн ирж, ХКН, МАХН-ын хооронд хэлхээ холбоо байгуулах асуудлаар хэлэлцээ хийж улмаар ХКН-ын төлөөлөгч Дин Дае 1929 оны 9-р сарын 9-нд МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгч гишүүдийн 50-р хуралд оролцож, хоёр намын хооронд хэлхээ холбоо байгуулахаар томилогдон ирсэн учир ба өөрийн намын байдлын тухай мэдээлж МАХН-д баяр хүргэсэн. МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурал уг асуудлыг хэлэлцээд тогтоохдоо: «Эдүгээ үеийн гадаад байдал түгшүүртэйн дээр ялангуяа япон ба хятадын цэргийн эрхтэн, эзэрхэг түрэмгий нараас бидний Монголын эрх чөлөөт байдлыг устгахыг эрмэлзэн бүхий үест мөн улсын доторхи эв хамт намаас хоёр намын хэлхээ холбоо байгуулахаар нөхөр Дин Даег ирүүлсэн нь туйлын чухал хэрэг» гэж тэмдэглэн үнэлээд цааш нь:

«...Манай Ардын Хувьсгалт Нам ба Хятадын Эв Хамт намууд бие биесийг үл итгэх буюу завсардах зүйл огтхон ч үгүй бөгөөд бүх дэлхийн улаан хувьсгалын халуун журмаар харилцахыг угталцуулан хандуулсны тулд одоо даруй дурдсан ёсоор хоёр намын хэлхээ холбоог туйлын зузаанаар байгуулж санал хүчийг нэгтгэн дорно зүгийн ба хоёр улсын ард түмний дайсан болох эзэрхэг түрэмгий ба цэргийн эрхтнүүдийг ховх цохин устгах... нийтлэг зорилтын талаар заасан байдаг.<sup>1</sup> Энэхүү Дин Дае бол ХКН-ын Төв Хорооны гишүүн бөгөөд 1928—1930 онд Хятадын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооноос Про-

финтернд сууж байсан төлөөлөгч Дэн Чжунся мөн юм. Тэр үед Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Төв Зөвлөлийн дарга байсан академич, ардын уран зохиолч Ц. Дамдинсүрэн (1908—1986) дурсагдаа: «...Дэн Чжунся 1929 онд Номхон далайн орнуудын Үйлдвэрчний эвлэлүүдийн их хуралд оролцсоны дараа Монголд ирэхэд нь миний бие танилцсан юм» гэж түүний дурсгалд зориулан 1952 онд бичсэн шүлгийнхээ оршилд бичсэн билээ.<sup>2</sup> Номхон далайн эргийн орнуудын ажилчны ба үйлдвэрчний эвлэлийн 2-р бага хурал 1929 онд Австралид хуралдах байсан боловч түүний харгис засгийн газар татгалзсаны улмаас Владивостокт хуралдсан ажээ. Түүний ажиллагаанд ЗХУ, Япон, Хятад, Филиппин, Индонези, АНУ, Англи, Францын үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчид оролцжээ. Мөн БНМАУ-ын Үйлдвэрчний Төв Зөвлөлийн төлөөлөгч бага хурлын ажилд оролцсон юм. Энэ бага хурал Номхон далайн эргийн орнуудын ажилчны ба үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөнийг дэлхийн шинэ дайны аюулын эсрэг тэмцэлд нэгтгэх, энх тайвныг сахин бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулжээ. Бага хурал мөн Ази ба Номхон далайн орнуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжсэн шийдвэр гаргасан байна.<sup>3</sup>

Мөн оны 9-р сард Профинтерний бие төлөөлөгч Монголд ирж үйлдвэрчний эвлэлийн ажилтай танилцаж, цаашдын ажлын талаар тодорхой заавар өгсөн тухай Б. Нямсамбуу зохиолдоо тэмдэглэсэн боловч чухам хэн гэгч ирснийг дурдсангүй. Бидний дээр дурдсан Дин Дае буюу Дэн Чжунся зөвхөн ХКН-ын төлөөлөгч төдий биш Профинтерний төлөөлөгчөөр БНМАУ-д ирсэн аж. Тэр дундад улсын бүх үйлдвэрчний эвлэлийн өмнөөс Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн Төв Зөвлөлтэй хэлэлцээ хийсэн нь 1929 оны 9-р сарын 17-нд «Монгол ба Дундад хоёр улсын ажилчин ардуудад тунхаглах нь» гэдэг тунхаг бичигт тусгасан байна.

Дэн Чжунся Монголын Үйлдвэрчний эвлэлийн төв Зөвлөлийн дарга Ц. Дамдинсүрэнтэй нэр хамтарч монгол, Хятад хоёр хэлээр Улаанбаатар хотноо хэвлэн гаргасан уг тунхаг бичгийг 54x71 см хэмжээний цаасан дээр хэвлэсэн агаад түүний эхэнд Хятадын хувьсгалыг дарж, олон улсын империалистуудад улсаа худалдсан цэргийн эрхтнүүд Гоминьдан хэмээх хөрөнгөтний намын удирдлагаар Хятад орныг дэлхийн ууган социалист орон —ЗХУ болон БНМАУ-ын эсрэг

\*Дэн Чжунся (1894-1933) Хунань мужийн хүн. 1919 оны 5-р сарын 4-ний хөдөлгөөнд идэвхтэй оролцсон. Тэрээр 1920 онд марксист бүлгэмд элсч 1922 онд ХКН-ын их хурлаас Төв Хорооны гишүүнээр сонгогджээ. 1927-1928 онд ХКН-ын Цзянсу, Гуандун зэрэг мужийн хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байгаад 1928—1930 онд олон улсын үйлдвэрчний байгууллага (Профинтерн)-д бүх Хятадын Үйлдвэрчний байгууллагын төлөөлөгчөөр сууж, түүний Гүйцэтгэх Хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байхдаа тийнхүү манай улсад айлчилсан ажээ. Дэн Чжунся 1930 онд эх орондоо буцаж очоод Хунань Хубэй мужийн хувьсгалын түшиц газарт ХКН-ын бүрэн эрхт төлөөлөгч Хятадын улаан цэргийн бүлгийн комиссараар томилогдон ажиллаж байгаад 1931 оноос Шанхай хотод нууц байдалд ажиллах болсон Дэн Чжунся 1933 оны 5-р сард Гоминьданы харгис цагдаад баривчлагдаж улмаар Нанжин хотод цаазлуулжээ. Тэрээр «Хятадын үйлдвэрчний хөдөлгөөний товч түүх» гэдэг ном бичиж 1930 онд хэвлүүлсэн юм. (Л. Ж.)

хийх түрэмгийллийн түшиц газар болгож байгааг дурдахдаа: «...Эзэрхэг түрэмгий нарын түлхээсээр Хятад орныг дэлхий дээр ганцаар нийгэм журмын ёсыг тогтоон байгуулж, хүн хүнээ мөлжих явдлыг устгаж, нийгэм тэгш байдлыг байгуулан үлгэр жишээ үзүүлж бүхий СССР улсыг тэмцэх газар болгож байгаагаас гадна нөгөөтэйгүүр олон зуун жилд Хятадын цэргийн эрхтний гарт байсаар үндэсний хувьсгалыг үйлдэж, олон түмэн ард нь улс төр, эдийн засаг ба эрдэм боловсролын явдлыг өөрсдийн гарт оруулан авч, өөрөө үйлдэж, үндэсний явдлыг хэрхэн шийтгэх хэрэгт олонд үлгэр болж байсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг эсэргүүцэн тэмцэх газар болгожээ» гэсэн байна.

Тунхаг бичигт Монголын хувьсгал, монгол хятадын ард түмний ангийн эв санааны нэгдлийн тухай өгүүлэхдээ: «...Монгол ардын хувьсгалт байдал хөгжсөөр явж дорно хязгаар дахь эзэрхэг түрэмгий нарын байдлыг сулруулсаар байх, үүнд монгол ард нь ганцаар бус бусад нөхөд нь олон байна. Хятадын олон үйлдвэрчин ардууд ба хувьсгалт тариачин ардууд нь монгол ардын эрх чөлөөт явдлыг хамгаалалцана» гэжээ. «Монгол ба Хятадын олон түмэн ажилчин ардууд аа! ...Эдүүгээ хятадын цэргийн эрхтэн нь харьяат хоёр улсын ард түмнийг хатуу харгисаар мөлжин дарлахыг завдаж бүхий энэ цагийн түгшүүртэй үед хүчээ хамтатган нэгдэж ангийн их тэмцээнийг (тэмцлийг Л. Ж.) эрхлэж эрх чөлөөт Монгол улс ба Хятадын хувьсгалын тэмцээнийг хамгаалахыг даллан уриална... Үндэсний эрх чөлөөг олох тэмцээнийг үндэс, ясыг баримтлахгүй мөлжигдөгч ангиас, мөлжигч ангийн эгтээдийг эсэргүүцэн тэмцэх ангийн их тэмцэл болгохыг цаг үргэлж бодлого болгон тэмцэгтүн! Урагшаа давшигтун! Нөхөд өө! Коминтерны удирдлагаар Монгол ба Хятадын олон үгээгүү түмэн ардууд нэгэн хамт явж бид нар хэзээд ялж чадна» гэж ангийн ба пролетарийн интернационалч нэгдэлтэй тэмцэхийг уриалсан нь МАХН, ХКН-ын хооронд тогтоосон ажил хэргийн хэлхээ холбооны зарчмын илрэл мөн. Өөрөөр хэлбэл хоёр намын хэлхээ холбооны зарчим ийнхүү хоёр орны хамгийн олон хүнийг хамарсан олон нийтийн байгууллага болох үйлдвэрчний байгууллагын тунхагийн хэлбэрээр олон түмний дунд түгсэн юм. Энэ түүхэн чухал баримт бичиг нийтлэгдсэнээс хойш жаран жил болж байгаа хугацаанд Монгол, хятад хоёр орон эн чацуу эрх тэгш социалист улсууд болон дэгжиж зуурдын бэрхшээлийг туулан, эрин цагийн шинэ өрнөлтөд ойртон нягтарч, нөхөрсөг хамтран ажиллах ашдын төлөв нээгдэж байна. Энэ үед одоо нэгэнт түүхт ховор баримт бичгийн дурсгал болсон энэхүү тунхагийн гэрэл зураг, бүрэн эрхийг хүндэт уншигч нарт толилуулж байна.

«Монгол улсын арван есдүгээр он есөн сарын арван долоон.

### **МОНГОЛ БА ДУНДАД ХОЁР УЛСЫН АЖИЛЧИН АРДУУДАД ТУНХАГЛАХ НЬ**

-Нөхөд өө! Хөдөлмөрчин, тариачны хувьсгалын явдлыг дарж Гуандун хотын эв хамтын хувьсгалыг цусан далайд оруулж баатар хувьсгалчдыг алж, хятад орныг гадаадын эзэрхэг түрэмгий нарт худалдсан Хятадын харгис цэргийн эрхтэн нь Гомиьндан хэмээх хөрөнгөтний намын удирдлага ба эзэрхэг түрэмгий нарын түлхээсээр хятад орныг дэлхий дээр ганцаар нийгэм журмын ёсыг тогтоон байгуулж хүн хүнээ мөлжих явдлыг устгаж, нийгэм тэгш байдлыг байгуулан, үлгэр



жишээ үзүүлж бүхий СССР улсыг тэмцэх газар болгож буйгаас гадна нөгөөтэйгүүр олон зуун жилд хятадын цэргийн эрхтний гарт байсаар үндэсний хувьсгалыг үйлдэж олон түмэн ард нь улс төр, эдийн засаг ба эрдэм боловсролын явдлыг өөрсдийн гарт оруулан авч өөрөө үйлдэж, үндэсний явдлыг хэрхэн шийтгэх хэрэгт олонд үлгэр болж байсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг эсэргүүцэн тэмцэх газар болгожээ.

Эдүүгээ бүрэн эрхт Монгол Ард Улсын олон түмэн ардууд амгалан тайвнаар өөрсдийн аж ахуй ба эрдэм боловсролыг эрх чөлөөт замаар хөгжүүлэн бүхий үед хятадын баячууд нь бүх дэлхийн эзэрхэг түрэмгий нартай хамт явж, монгол ардын эрх чөлөө бүхий хувьсгалт байдлыг устгаад ариун цэвэр нутаг орны нь үхсэн хүний биеэр дүүргэж, энэхүү эрх чөлөөт байдлыг байгуулах гэсэн монголын сайн сайн үрс хүүхдийн цусыг урсгуулж, харьяат Монгол орныг олон улсын эзэрхэг түрэмгий нарын идэш болгохыг эрмэлзэж буй нь илэрхий болой. Хэзээний эрх чөлөөгөө олсон монгол улсыг хятадын ноёд генералууд нь үл ойшоон байсаар ирсэн хэдүй боловч үнэнч хувьсгалын явдал нь тэдгээрийг наадамлан инээмсэглэн үзэж хөгжсөөр эдүүгээ найман жил болоод байна.

Монголын эрх чөлөө бүхий эл байдлыг олон улсын хүний цусыг хөхөгч алуурч эзэрхэг түрэмгий нар үл ойшоотугай ч монгол ардын хувьсгалын хэрэг цааш хөгжиж чадна. Энэхүү монгол ардын хувьсгалт байдал хөгжсөөр явж дорно хязгаар дахь эзэрхэг түрэмгий нарын байдлыг сулруулсаар байх үүнд монгол ард нь ганцаар бус бусад нөхөд нь олон байна.

Хятадын олон үйлдвэрчин ардууд ба хувьсгалт тариачин ардууд нь монгол ардын эрх чөлөөт явдлыг хамгаалалцана. Монгол ардын эрх чөлөөгөө авсан өдрөөс эхлэн хятадын үйлдвэрчин ба хувьсгалт тариачин нь зөвшөөрөх төдийгөөр үл барам таны эрх чөлөө ба ашиг тусаа олох хамгаалах явдал нь бидэнтэй нэгэн адил хэмээсээр уг зорилго бол өөрсдийн цэргийн эрхтэн ба баячууд хөрөнгөтөн хийгээд бүх дэлхийн эзэрхэг түрэмгий нарыг устгах явдал мөн амуй. Эдүүгээ бол эзэрхэг түрэмгий нарын тусламжаар явж байгаа хятадын цэргийн эрхтэн нь Монголын эрх чөлөө бүхий байдлыг бүрмөсөн устгаж эзлэн авахыг цаг ямагт завдан оролдож буй. Монгол ба Хятадын олон түмэн ажилчин ардууд аа! Бүх Хятадын үйлдвэрчний эвлэлүүдийн Холбоо ба Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн төв зөвлөлөөс эдүүгээ Хятадын цэргийн эрхтэн нь харьяат хоёр улсын ард түмнийг хатуу харгисаар мөлжин дарлахыг завдаж бүхий энэ цагийн түгшүүртэй үед хүчээ хамтатган нэгдэж ангийн их тэмцээнийг эрхлэж эрх чөлөөт Монгол улс ба хятадын хувьсгалт тэмцээнийг хамгаалахыг даллан уриална. Монголын олон түмэн ардууд аа! Өөрийн хувьсгалын явдлыг улам бүр хөгжүүлж аж ахуйгаа зузаатгаж улс төрөө хамгаалах хүчийг нэмэгдүүлж улаан цэрэгтээ туслаж олон ардууд өөрсдийн эрх чөлөөг хамгаалагтун! Та нар ганцаар бус. Та нарын нөхөд олон буй. Хятадын үйлдвэрчин ардууд тан лугаа хамт явж эзэрхэг цэргийн эрхтнийг эсэргүүцнэ хэмээн бэлэн буй. Хятадын үйлдвэрчин ба хувьсгалч тариачин ардууд аа! Танай эзэрхэгүүдийн зүгээс Монгол улсад халдан ирэх явдлыг сайтар сэргийлж монгол улсыг хамгаалахад бэлхэн байгтун! Үндэсний эрх чөлөөг олох тэмцээнийг үндэс ясыг баримтлахгүй мөлжигдөгч ангиас мөлжигч ангийн этгээдийг эсэргүүцэн тэмцэх ангийн их тэмцэл болгохыг цаг үргэлж бодлого болгон тэмцэгтүн!

---

Урагш давшигтун! Нөхөд өө! Коминтерны удирдлагаар монгол ба хятадын олон үгээгүү түмэн ардууд нэгэн хамт явж бид нар хэзээд ялж чадна.

Дундад улсын Үйлдвэрчний Бүх Эвлэлийн төлөөлөгч

**Дин Дае**

Монголын Үйлдвэрчний Төв Зөвлөл

**Дамдинсүрэн**

1. МАХН-ын Түүхийн Төв Архив. Ф1, т. 34 ХН—17, 10—11-р талд
2. Ц. Дамдинсүрэн. Түүвэр зохиол. УБ., 1956, 109-рт
3. Б. Нямсамбуу. Профинтерн ба Монголын Үйлдвэрчний эвлэл УБ., 1967, 57-рт